



**14 СУМЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БИЕ ЗАСАХ
БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР**


2023.07.20

Алтай хот

№	Хийгдэх ажлын нэр	Бүрдүүлэх баримт, гарах үр дүн
1.	Нийтийн бие засах газар	14 сумын нийтийн эзэмшлийн талбайд бие засах байгууламж барих (зөөврийн боловсон жорлон)
2.	Байршил	Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ (14 сум)
3.	Захиалагч байгууллага	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
4.	Ажлын тоо хэмжээ, тавигдах шаардлага	<p>Тавигдах шаардлага</p> <ul style="list-style-type: none"> ❖ Ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир ус, дулааны шугам хоолойн байрлал болон угсралт нь БНБД 40-06-16- "Дотор сантехникийн систем"-ийн шаардлагад нийцсэн байна. ❖ Бие засах суултуурын өрөө, гар угаах өрөөний ханыг (доторлогоог) ус чийгэнд тэсвэртэй, галд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалыар хийсэн байна. ❖ Дотор талын ус, цахилгаан, дулааны шугамыг далд хийцээр хийнэ. ❖ Ус зайлзуулах хоолойн гарах, шугам хоолойг PVC материалыар хийнэ. ❖ Цэвэр, бохирыг бүрэн шийдвэрлэх ❖ Хаалганы цоож бат бэх, гадна, дотроосоо онгойдог байна. ❖ Ариун цэврийн байгууламжийн барилгын гадна талын хаягийг босоо хэлбэрээр, нүдэнд шууд харагдах газар угсарч байрлуулна. ❖ Суултуурын тусгаарлах хаалт нь бат бэх, ус чийг, ялзral элэгдлийн хамгаалалттай, цэвэрлэхэд хялбар материалыар хийгдсэн байна. Өргөн нь 0.45 м-ээс, өндөр нь 0.8 м-ээс багагүй байна. Тусгаарлах хавтанд тавиур, тавцан угсрах, тодорхой даац авах боломжтой байна. ❖ Эрэгтэй, эмэгтэй тусдаа ариун цэврийн өрөөний гар угаах угаалтуурын тоог MNS 6392:2013 "Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага" /4.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага /MNS 4236:2003/-ын дагуу төлөвлөнө. <p>Ажлын тоо хэмжээ</p> <p>Нийтийн бие засах боловсон жорлон нь дотор хэсэгт техникийн өрөө болон бие засах өрөө буюу үндсэн байгууламж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ (тасалгаатай).</p> <p><u>Байгууламжийн гадна хэсэг:</u></p> <p>Сууж бие засах зориулалттай байгууламж нь өвлийн улиралд ашиглаж болохуйц дулаалга, доторлогоотой (хана, тааз, шал гэх мэт) урт 6 м, өргөн 2.4 м-ээс багагүй хэмжээтэй тохижуулсан 20 тн-ын контейнер байна.</p> <p>Контейнерын гадаргууг ус, чийгэнд тэсвэртэй төмрийн зориулалтын будгаар будах байх бөгөөд цагаан саарал</p>


		<p>өнгөтэй, хүрээг цагаан өнгөөр будна.</p> <p>Цонх: Битүүмжлэл сайтай 0.5 м x 0.8 м хэмжээтэй вакум цонх 2 ширхэг.</p> <p>Хaalга: Дулаалгатай, бат бэх 0.96 м x 2.05 м хэмжээтэй хаалга байна.</p> <p>Шал: Хөөсөн хавтангаар дулаалж, модон шалтай (захиалагчтай зөвшилцэх) байна.</p> <p>Хана, тааз: Дулаалгатай доторлогоо хийнэ. (материалыг захиалагчтай зөвшилцэх)</p> <p><u>Дотор хэсэг:</u></p> <p>Байгууламжийн дотор зохион байгуулалт нь техникийн болон бие засах өрөө буюу үндсэн байгууламж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.</p> <p>1. Бие засах буюу үндсэн байгууламж хэсэгт дараах бүрдэл орно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> 1.1. Суултуур болон түүний дагалдах тоног төхөөрөмж нь бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй байх бөгөөд 4 суултуур (эрэгтэй, эмэгтэй) байна. 1.2. Байгууламж дотор 4 тасалгаатай байх бөгөөд тасалгааг бат бэх хавтангаар хийж, бие засах өрөөний хаалганы нээгдэх хэмжээ 0.6 м x 2 м, кабин хэмжээ нь 35 м x 150 м-ээс багагүй байна. <p>2. Техникийн өрөө</p> <ul style="list-style-type: none"> 2.1. Нөөцийн зориулалтын сав 1 тн багтаамжтай байх; 2.2. Халуун, хүйтэн усны 80 Вт-ын бойлер байрлуулах; 2.3. Сантехникийн шугам хоолойг PVC материалыар хийнэ. Диаметр нь 160 мм-ээс багагүй байна. 2.4. Насос суурилуулах (550 Вт-аас багагүй); <p><u>Нэмэлт тоноглол:</u></p> <ul style="list-style-type: none"> 1. Угаалтуур 2 ширхэг 2. Розетик 4 ширхэг (техникийн өрөөнд-1, бусад-3) 3. Бүх цахилгаан холболтыг бүрэн шийдэх 4. Унтраалга 3 ширхэг (техникийн өрөөнд-1, бусад-3) 5. Гэрэл 4 ширхэг (техникийн өрөөнд -1, бусад-3) 6. Цаас болон саван тогтоогч тус бүр 2 ширхэг 7. Толь 2 ширхэг
6.	Хийж хүлээлгэн өгөх хугацаа	Тус ажлыг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөрт багтаан хийж дуусгаж, хүлээлгэн өгнө.
7.	Багц ажлын үнэ	14 сум тус бүр 25,000,000 (хорин таван зуун сая) төгрөгт (хийж гүйцэтгэх, ажиллах хүчиний зардал зэрэг багтсан болно.)
8.	Гүйцэтгэгч байгууллагад тавих шаардлага	<ul style="list-style-type: none"> ❖ Чанартай хийж гүйцэтгэн 14 хоногт багтаан нийлүүлэх ❖ Баталгаа 1 жил байх бөгөөд гүйцэтгэгч эвдрэл гэмтлийг өөрийн хөрөнгөөр засварлах ❖ Ижил төстэй ажил хийж байсан туршлагатай байх

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ш. ЭРДЭНЭБАТ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨӨТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ХАШ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  Ж.МӨНХЧИМЭГ